

САЙХАН СУМЫН 2017 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН СҮҮЛИЙН ХАГАСТ ЗОХИОН БАЙГУУСАН ДОТООД АЖЛЫН МЭДЭЭ

2017.01.27

Их Хүрэмт

2017 оны 01 дүгээр сарыг сар болгон “сарын аян” зарлан сумын Засаг даргын захирамж гарган ажиллаж байна. Энэ хүрээнд бүх албан хаагч, байгууллага бүр жилийн ажлын төлөвлөгөөгөө гарган батлуулан ажиллаж байна.

Сумын Соёлын төв сар бүр байгууллагуудтай хамтран ажиллах хүрээнд 1 дүгээр сарыг ЗДТГазартай хамтран үндсэн хуулийн өдөрт зориулан байгууллага, багуудын хооронд танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд ороцсон хүмүүсийн дунд танин мэдэхүйн асуулт, сумын түүх соёлын турсгалт газрын талаар, “Үндсэн хууль”-ийг хэн сайн мэдэх вэ? асуулт хариултын тэмцээнийг тус тус зохион байгууллаа. 1-р байранд Хүрэмт баг, 2-р байр Цэцэрлэгийн хамт олны “Smile” баг, 3-р байрыг “Мануулт” багаас оролцсон “Хунт” баг тус тус эзэллээ.



Сумын Засаг дарга сар бүрийн 1,15-ны өдөр байгууллагын дарга эрхлэгч нар болон төрийн захиргааны албан хаагчидтай цаг үеийн ажлаар шуурхай зөвлөгөөнийг хийж хэвшсэн. Шуурхай зөвлөгөөнөөр Булган аймагт зохион байгуулагдсан “Төрийн албан хаагчдын нэгдсэн” зөвлөгөөний талаарх мэдээллийг хийж хариуцлагыг сайжруулах, ёсзүйтэй ажиллах, семинараар өгсөн үүрэг чиглэлийг танилцууллаа.

1 сарын 25-ны өдөр Байгаль орчны албанаас “Сумаа хэн сайн мэдэх вэ?” АХА тэмцээнийг бүх байгууллага, иргэдийн дунд зохион байгууллаа.



Сумын Засаг дарга багийн Засаг дарга нар болон байгууллагын дарга эрхлэгч нартай бүтээлч даалгавар, 2017 оны үр дүнгийн гэрээ, хариуцлагын гэрээг байгууллаа. Энэ жил шинээр хариуцлагын гэрээг нэмэлтээр 18 заалттайгаар оруулсан. Мөн бүтээлч даалгаврыг аймгийн Засаг даргын "Хөгжлийн хөтөч" үйл ажиллагааны хөтөлбөр, сумын Засаг даргын "Сумандаа Сайхан амьдарья" хөтөлбөрүүдийн хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлыг 6-8 заалттайгаар тусгасан.





Хууль сурталчилах хүрээнд сар бүр тогтмол сургалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

ЗДТГазар